

ШУА- ийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүний ажилтан, шилдэг залуу судлаач, Инженер техникийн тэргүүний ажилтан, шилдэг бүтээл шалгаруулах журамдын төсөл

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь хүрээлэнгийн эрдэм шинжилгээний болон инженер техникийн ажилтан, эрдэм шинжилгээний бүтээлийг дүгнэхтэй холбогдуулан үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Уг журмыг хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлаар батална.
- 1.3. Хүрээлэн нь жилд нэг удаа эрдэм шинжилгээний тэргүүний ажилтан, шилдэг залуу судлаач, инженер техникийн тэргүүний ажилтан, шилдэг бүтээлийг энэхүү журамд заасан үнэлгээгээр шалгаруулна.

Хоёр. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг дүгнэх

- 2.1. Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг нэгтгэн хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллүүдийг дараах оноогоор дүгнэнэ (хэвлүүлсэн өгүүлэлийн эхний 2 авторийн нэг бол бүтэн оноог, харин 2-оос хойших автор бол онооны 50% өгнө. Нийт оноо 150-аас хэтрэхгүй).
 - 2.1.1. Гадаадын инпакт фактортай сэтгүүлд 1-удаа хэвлүүлсэн бол 100 оноо, 2 болон түүнээс олон хэвлүүлсэн бол 150 оноо.
 - 2.1.2. Гадаадын инпакт фактор байхгүй сэтгүүлд 1-удаа хэвлүүлсэн бол 60 оноо, 2 болон түүнээс олон хэвлүүлсэн бол 100 оноо.
 - 2.1.3. Гадаадад инпакт фактор байхгүй сэтгүүлд 1, дотоодод 1-ээс дээш хэвлүүлсэн бол 80 оноо.
 - 2.1.4. Дотоодын сэтгүүлд 1-удаа хэвлүүлсэн бол 40 оноо, 2 болон түүнээс олон хэвлүүлсэн бол 60 оноо.
 - 2.1.5. Гадаад болон дотоодын сэтгүүл гэдэгт эрдэм шинжилгээний илтгэлийн абстракт болон өргөтгөсөн абстракт нь хэвлэгдсэн товихмолыг тооцохгүй. **(Баасанбат)**
- 2.2. Судалгааны ажлын үр дүнг нэгтгэсэн нэгэн сэдэвт бүтээл гаргасан бол дараах оноогоор дүгнэнэ. (150 оноо хүртэл)
 - 2.2.1. Англи хэл дээр 130 оноо.
 - 2.2.2. Монгол хэл дээр 70 оноо.
 - 2.2.3. Докторын дипломын ажлыг 120 оноогоор, магистрийн дипломын ажлыг 60 оноогоор үнэлнэ. **(Мөнгөнсүрэн)**
- 2.3. Эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьсан байдлыг дараах оноогоор үнэлнэ (70 оноо хүртэл).
 - 2.3.1. Олон улсын эрдэм шинжилгээний хуралд аман илтгэл тавьсан бол 50 оноог, ханын илтгэл тавьсан бол 30 оноог (эрдэм шинжилгээний ажилтан өөрөө тавьсан байна.1 удаа).
 - 2.3.2. Бусад эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд аман илтгэл тавьсан бол-30 оноо, ханын илтгэл тавьсан бол 20 оноог (1 удаа).
 - 2.3.3. Хүрээлэн дээр нэгдсэн семинар хийсэн бол 20 оноо (1 удаа).

- 2.4. Хүрэл тогоот эрдэм шинжилгээний хуралд оролцсон залуу судлаачид нийт гарсан оноон дээр 100 хүртэл оноог нэмж тооцоно. (байгууллагын хуралд 50!)
- 2.5. Судалгааны ажилд ашиглагдах програм шинээр зохиосон, багаж техник тоног төхөөрөмж бий болгосон дараах оноогоор үнэлнэ (40 хүртэл оноо).
 - 2.5.1. Судалгааны ажилд ашиглагдах программ зохион зүгшрүүлж, боловсруулалтад ашиглаж эхэлсэн бол сэдэв, төслийн удирдагч, салбар, лабораторийн эрхлэгч нарын тодорхойлолтыг үндэслэн 20 оноогоор үнэлнэ.
 - 2.5.2. Судалгааны ажилд ашиглагдах багаж тоног төхөөрөмж, зарим эд ангийг зохион бүтээж туршин ашиглаж эхэлсэн бол сэдэв, төслийн удирдагч, салбар, лабораторийн эрхлэгч нарын тодорхойлолтыг үндэслэн 20 оноогоор үнэлнэ.
 - 2.5.3. Судалгааны ажилд ашиглагдах гарын авлага, заавар бичиж хэвлүүлсэн бол 20 оноогоор үнэлнэ.
- 2.6. Багаж тоног төхөөрөмж, техникийн хэвийн ажиллагаа, мэдээлэл бүрдүүлэлт, хээрийн судалгаа, боловсруулалтын ажлын гүйцэтгэлийг сэдвийн удирдагчийн саналаар сайн (20), дунд (10) гэсэн суурь оноогоор дүгнэнэ.

Гурав. Шинжлэх ухаан, танин мэдэхүйн талаар

- 3.1 Шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлээр гадаад, дотоодын хэвлэлд нийтлүүлсэн ном, өгүүлэл бүрийг дараах байдлаар тус тус дүгнэнэ (70 хүртэл оноо).
 - 3.1.1 Гадаадад хэвлүүлсэн бол 50 оноо (1 удаа).
 - 3.1.2 Дотоодод хэвлүүлсэн 1 удаа хэвлүүлсэн бол 20 оноо, 2 болон түүнээс олон хэвлүүлсэн бол 40 оноо.
 - 3.1.3 Шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлээр ном хэвлүүлсэн бол 50 оноогоор үнэлнэ.
 - 3.1.4 Зурагт хуудас, үзүүлэн таниулах материал, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сургалт сурталчилгаа хийсэн бол 10 онооны үнэлгээ өгнө.

Дөрөв. Судалгааны үр дүнг үйлдвэр, практикт нэвтрүүлэх талаар

- 4.1 Судалгааны үр дүнг үйлдвэрлэлд, практикт нэвтрүүлэх зорилгоор гэрээт ажил гүйцэтгэсэн байвал ажлын гүйцэтгэлийг харгалзан 20 оноогоор дүгнэнэ (1 удаа).
- 4.2 Судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэн шинэ бүтээлийн патент, ашигтай загварын гэрчилгээ авсан бол 100 оноогоор үнэлнэ (1 удаа).

Тав. Их, дээд сургуульд ажиллаж байгаа талаар

- 5.1 Их, дээд сургуулиудад мэргэжлийн чиглэлээр хичээл заадаг бол заасан улирал тутамд 10 оноогоор дүгнэнэ (20 оноо хүртэл).
- 5.2 Бакалавр, магистр, докторын дипломыг удирдаж ажилласан бол удирдсан хүний тоогоор 5 оноогоор үнэлнэ (15 оноо хүртэл).
- 5.3 Эрдмийн цол хүртсэн бол 30, 50 оноогоор үнэлнэ (Дэд профессор, Профессор).

Зургаа. Инженер техникийн тэргүүний ажилтан шалгаруулах

- 6.1 Шилдэг инженер техникийн ажилтан шалгаруулахад дээрх шалгуурыг шилдэг эрдэм шинжилгээний ажилтны адил дүгнэх ба дараах шалгуурыг нэмж тооцно.

- 6.2 Тухайн инженер техникийн ажилтны хариуцсан станц, багаж тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааны ажилласан хувиас хамааруулан 10- 100 хүртэл оноогоор үнэлнэ.
- 6.3 Багаж тоног төхөөрөмж ашиглах заавар боловсруулсан, гадаад хэлнээс орчуулсан бол 30 оноогоор үнэлнэ.
- 6.4 Багаж тоног төхөөрөмжийн хэрэглэх болон хэвийн үйл ажиллагааг хянахад шинэ арга зүй нэвтрүүлсэн бол 30-70 хүртэлх оноогоор үнэлнэ.

Долоо. Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах

- 7.1. Эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийг шалгаруулахдаа хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан нь тухайн бүтээлийн эхний 2 авторын нэг байна.
- 7.2. Эрдэм шинжилгээний шилдэг бүтээлээр тухайн жилд хамгийн өндөр импакт фактортай сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлд олгоно.
- 7.3. Эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн хэвлүүлсэн сэгүүлийн импакт фактор нь 2 оос доошгүй байна. (Web sciences)

Найм. Төвийн захиргаа, хамт олны зүгээс өгөх үнэлгээ

- 8.1. Хүрээлэнгийн нийт ажилтан, ажилчдын дунд зохиогддог олон нийтийн ажилд идэвх, санаачилгатай оролцдог бол Захиргааны саналыг үндэслэн тэргүүний ажилтныг 20 хүртэлх оноогоор үнэлнэ.

Ес. Эрдэм шинжилгээний ажилтнуудын ажлыг дүгнэх явц

- 9.1. Эрдэм шинжилгээний тэргүүний ажилтан, залуу эрдэм шинжилгээний тэргүүний ажилтан, инженер техникийн тэргүүний ажилтанг тухайн жилд дээрх шалгуураар дүгнэн 200 онооноос дээш гарсан тохиолдод шалгаруулна
- 9.2. Эрдэм шинжилгээний тэргүүний ажилтныг нийт эрдэм шинжилгээний ажилтнуудын дундаас, эрдэм шинжилгээний шилдэг залуу ажилтныг 35 хүртэлх насны эрдэм шинжилгээний ажилтнуудын дундаас шалгаруулна.
- 9.3. Сэдэв, төслийн удирдагч нар эрдэм шинжилгээний ажилтнууд болон шилдэг бүтээлүүдийг дээрх журмын дагуу дүгнэж нэгтгэсэн дүнгээ Хүрээлэнгийн захиргаанд 12-р сарын 10-ны дотор ирүүлсэн байна.
- 9.4. Тухайн оны Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүний ажилтан, шилдэг бүтээлийн шагналыг Хүрээлэнгийн шинэ жилийн баяр ёслолын арга хэмжээний үеэр гардуулна.

Дүгнэвэл

Өгүүлэл	150
Нэгэн сэдэвт бүтээл	130
Илтгэл	70
Программ хангамж ба багаж хөгжүүлэлт	40
Сэдвийн удирдагч(оролцоо)	20
ХҮРЭЛ ТОГООТ (залуу)	100
ШУ танин мэдэхүй	70
Гэрээт ажил	20
Патент, ашигтай загвар	120
Багшлах	20
Диплом удирдах	15

